

УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Тариалан сумын Ерөнхий боловсролын нэгдүгээр сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: УВА-2023/102/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn
Улаангом хот
2023 он

Увс аймаг дахь Төрийн аудитын газар,
Дарга, тэргүүлэх аудитор: М.Батсуурь
Утас: 70453317, Цахим хаяг: BatsuuriM@audit.gov.mn
Аудитын менежер: М.Бат-Амгалан
Утас: 70453799, Цахим хаяг: Bat-Amgalanm@audit.gov.mn
Гэрээгээр аудитыг гүйцэтгэсэн "Увс Финанс аудит" ХХК
аудитор: Я.Тунгалаг
Утас: 99458717 Цахим хаяг:ynarantuya310@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**УВС АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213400, Увс аймаг, Улаангом сум,
Ө.Бадрахын гудамж
Утас: 70-45-33-17, Факс: (976)70-45-33-17,
E-mail: uvs@audit.gov.mn

ТАРИАЛАН СУМЫН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН НЭГДҮГЭЭР
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ
П.НЯМДАВАА ТАНАА

2023.02.24 № УДА-2023/102/НА-СТА-ТМЗ

танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Тариалан сумын Ерөнхий боловсролын нэгдүгээр сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Тариалан сумын Ерөнхий боловсролын нэгдүгээр сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Боловсрол шинжлэх ухааны яамнаас үнэ төлбөргүй 6,837.4 мянган төгрөгийн ном, 5,801.9 мянган төгрөгийн тоног төхөөрөмж хүлээн авсан, төсвийн хөрөнгөөр 56,564.4 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга хэрэгсэл худалдан авсан байна.

Аудитын гол асуудал

АДБОУС 2701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ байхгүй болно.

Бусад асуудлын хэсэг

Санхүүгийн тайлангийн тодруулга толилуулгад тусгаагүй, аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй асуудал гараагүй болно.

0200200461

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.БАТСУУРЬ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	3
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	11
4.1 Ерөнхий зүйл.....	14
4.2 Материаллаг байдал	14
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	14
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	14
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	14
4.5.1 Завсрын аудитын талаар	15
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	15
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	15
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	16

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТШЗ	Төсвийн шууд захирагч
НА	Нийцлийн аудит

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1. Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>133,749,019.24</u>	<u>172,283,023.03</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	00.00	30,262,352.79
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	00.00	30,262,352.79
3121	Төгрөг	00.00	30,262,352.79
31211	Төрийн сангийн харилцах	00.00	30,262,352.79
35	БАРАА МАТЕРИАЛ	133,749,019.24	142,020,670.24
351	Түүхий эд материал	196,809.00	00.00
35130	Эм боох материал	196,809.00	00.00
354	Хангамжийн материал	133,552,210.24	142,020,670.24
35410	Бичиг хэргийн материал	931,602.24	931,602.24
35420	Аж ахуйн материал	121,398,728.00	128,916,878.00
35460	Хүнсний материал	4,517,680.00	5,467,990.00
35470	Бусад хангамжийн материал	6,704,200.00	6,704,200.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>5,386,561,472.34</u>	<u>5,274,242,704.50</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	5,386,561,472.34	5,274,242,704.50
392	Биет хөрөнгө	5,293,041,472.34	5,180,722,704.50
39201	Барилга, байгууламж, орон сууц	5,688,454,480.00	5,688,454,480.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-583,942,908.49	-722,895,379.77
39203	Авто-тээврийн хэрэгсэл	29,700,000.00	29,700,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-7,425,000.00	-11,137,500.00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	333,202,045.30	392,948,437.80
39206	Хуримтлагдсан элэгдэл	-269,366,798.70	-292,299,543.13
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	190,884,045.78	193,284,045.78
39208	Хуримтлагдсан элэгдэл	-114,677,464.91	-130,602,299.42
39217	Ном	26,213,073.36	33,270,463.24
393	Биет бус хөрөнгө	93,520,000.00	93,520,000.00
39301	Програм хангамж	800,000.00	800,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-800,000.00	-800,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	93,520,000.00	93,520,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>5,520,310,491.58</u>	<u>5,446,525,727.53</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>5,520,310,491.58</u>	<u>5,446,525,727.53</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	5,520,310,491.58	5,446,525,727.53
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	905,057,582.98	905,057,582.98
51101	Өмч: - төрийн	905,057,582.98	905,057,582.98
512	Хуримтлагдсан үр дүн	4,398,129,112.55	4,324,344,348.50
51210	Өмнөх үеийн үр дүн	4,398,129,112.55	4,398,129,112.55
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-73,784,764.05
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	217,123,796.05	217,123,796.05
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>5,520,310,491.58</u>	<u>5,446,525,727.53</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,509,883,731.24	1,894,942,652.38
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	3,181,766.24	15,189,352.38
120	Нийтлэг татварын бус орлого	3,181,766.24	15,189,352.38
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	3,181,766.24	15,189,352.38
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	105,000.00	00.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	2,550,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	3,076,766.24	12,639,352.38
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	268,464,365.00	1,879,753,300.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	00.00	1,547,686,800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	00.00	1,547,686,800.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,238,237,600.00	00.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	9,095,365.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	9,095,365.00	00.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	259,369,000.00	332,066,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	259,369,000.00	332,066,500.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,670,328,268.37	1,968,727,416.43
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,670,328,268.37	1,968,727,416.43
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,606,463,463.19	1,896,922,818.43
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	938,896,051.00	1,098,196,302.36
210101	Үндсэн цалин	638,772,017.00	790,897,299.05
210102	Нэмэгдэл	229,594,051.00	264,839,124.81
210104	Урамшуулал	60,528,567.00	42,459,878.50
210105	Гэрээт ажлын хөлс	10,001,416.00	00.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	123,237,744.82	137,964,764.85
210201	Тэтгэврийн даатгал	86,270,447.34	94,881,848.15
210202	Тэтгэмжийн даатгал	9,329,175.88	11,162,563.09
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,453,311.21	8,879,650.57
210204	Ажилгүйдлийн даатгал	1,820,632.87	2,090,125.38
210205	Эрүүл мэндийн даатгал	18,364,177.52	20,950,577.66
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	252,203,349.00	249,770,152.00
210301	Гэрэл, цахилгаан	4,321,147.00	6,413,850.00
210302	Түлш, халаалт	245,481,320.00	240,901,102.00
210303	Цэвэр, бохир ус	2,400,882.00	2,455,200.00
2104	Хангамж, бараа материалын зардал	11,523,185.00	7,542,700.00
210401	Бичиг хэрэг	838,965.00	358,800.00
210402	Тээвэр, шатахуун	3,532,520.00	1,380,500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	641,000.00	00.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,777,100.00	00.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,733,600.00	5,803,400.00
2105	Нормативт зардал	79,793,081.00	175,822,749.00

210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,251,151.00	2,081,409.00
210502	Хоол, хүнс	78,285,930.00	170,884,340.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	256,000.00	2,857,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,299,990.00	2,500,000.00
210604	Урсгал засвар	3,299,990.00	2,500,000.00
2107	Томилолт, зочны зардал	896,000.00	2,267,000.00
210702	Дотоод албан томилолт	896,000.00	2,267,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	700,200.00	10,668,200.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	403,200.00	403,200.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	297,000.00	10,265,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	195,913,862.37	212,190,950.22
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	20,254,600.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	8,285,050.00	10,413,800.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	187,628,812.37	181,522,550.22
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	63,864,805.18	71,804,598.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	33,525,400.00	71,191,500.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	30,575,400.00	71,191,500.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,950,000.00	00.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	26,473,754.18	00.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	26,473,754.18	00.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	3,865,651.00	613,098.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,865,651.00	613,098.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-160,444,537.13	-73,784,764.05

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

		/төгрөг/	
Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,506,806,965.00	1,886,197,200.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	105,000.00	6,443,900.00
120	Нийтлэг татварын бус орлого	105,000.00	6,443,900.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	105,000.00	6,443,900.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	105,000.00	3,893,900.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	2,550,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,506,701,965.00	1,879,753,300.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	00.00	1,547,686,800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	00.00	1,547,686,800.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,238,237,600.00	00.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	9,095,365.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	9,095,365.00	00.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	259,369,000.00	332,066,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	259,369,000.00	332,066,500.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,504,000,965.00	1,855,934,847.21
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,504,000,965.00	1,855,934,847.21
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,440,136,159.82	1,784,130,249.21
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	938,896,051.00	1,098,245,626.36
210101	Үндсэн цалин	638,772,017.00	791,263,052.59
210102	Нэмэгдэл	229,594,051.00	264,601,206.43
210104	Урамшуулал	60,528,567.00	42,381,367.34
210105	Гэрээт ажлын хөлс	10,001,416.00	00.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	123,237,744.82	137,915,440.85
210201	Тэтгэврийн даатгал	86,270,447.34	94,609,572.94
210202	Тэтгэмжийн даатгал	9,329,175.88	11,130,601.21
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,453,311.21	8,901,060.85
210204	Ажилгүйдлийн даатгал	1,820,632.87	2,210,872.65
210205	Эрүүл мэндийн даатгал	18,364,177.52	21,063,333.20
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	253,003,349.00	249,770,152.00
210301	Гэрэл, цахилгаан	4,321,147.00	6,413,850.00
210302	Түлш, халаалт	246,281,320.00	240,901,102.00
210303	Цэвэр, бохир ус	2,400,882.00	2,455,200.00
2104	Хангамж, бараа материалын зардал	13,884,420.00	00.00
210401	Бичиг хэрэг	664,800.00	00.00
210402	Тээвэр, шатахуун	3,532,520.00	00.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	641,000.00	00.00
210404	Ном, хэвлэл	2,273,000.00	00.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	4,003,100.00	00.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,770,000.00	00.00

2105	Нормативт зардал	86,065,730.00	171,834,650.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,342,130.00	00.00
210502	Хоол, хүнс	82,803,600.00	171,834,650.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,920,000.00	00.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	15,500,000.00	5,500,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	13,000,000.00	00.00
210604	Урсгал засвар	2,500,000.00	5,500,000.00
2107	Томилолт, зочны зардал	896,000.00	00.00
210702	Дотоод албан томилолт	896,000.00	00.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	700,200.00	14,158,900.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	00.00	3,893,900.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	403,200.00	00.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	297,000.00	10,265,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	7,952,665.00	106,705,480.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	91,266,930.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	7,952,665.00	15,438,550.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	63,864,805.18	71,804,598.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	33,525,400.00	71,191,500.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	30,575,400.00	71,191,500.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,950,000.00	00.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	26,473,754.18	00.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	26,473,754.18	00.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	3,865,651.00	613,098.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,865,651.00	613,098.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	2,806,000.00	30,262,352.79
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	2,806,000.00	00.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	2,806,000.00	00.00
2200	Дотоод эх үүсвэрээр	2,806,000.00	00.00
223001	Бусад хөрөнгө	2,806,000.00	00.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-2,806,000.00	00.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	30,262,352.79
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	30,262,352.79

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

						/төгрөг/
Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2021 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00	0.00
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00	0.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00	0.00
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	0.00	0.00	0.00	0.00	0.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	0.00	0.00	0.00	0.00	0.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00	0.00
C07	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	0.00	0.00	0.00
C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	905,057,582.98	217,123,796.05	4,398,129,112.55	00.00	5,520,310,491.58
D01	2022 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	905,057,582.98	217,123,796.05	4,398,129,112.55	00.00	5,520,310,491.58
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	905,057,582.98	217,123,796.05	4,398,129,112.55	00.00	5,520,310,491.58
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-73,784,764.05	00.00	-73,784,764.05
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	905,057,582.98	217,123,796.05	4,324,344,348.50	00.00	5,446,525,727.53

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан /улсын төсөв/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	гүйцэтгэл	/төгрөг/	
				Зөрүү	биелэлт
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,554,130,700.0	1,523,868,347.2	30,262,352.8	98.05
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,554,130,700.0	1,523,868,347.2	30,262,352.8	98.05
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,482,353,900.0	1,452,676,847.2	29,677,052.8	98.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,044,063,700.0	1,030,515,505.4	13,548,194.6	98.70
210101	Үндсэн цалин	798,446,000.0	734,130,277.6	64,315,722.4	91.94
210102	Нэмэгдэл	229,665,600.0	259,328,107.4	-29,662,507.4	112.92
210104	Урамшуулал	15,952,100.0	37,057,120.3	-21,105,020.3	232.30
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	130,508,000.0	129,462,311.9	1,045,688.2	99.20
210201	Тэтгэврийн даатгал	88,745,400.0	88,745,400.0	0.0	100.00
210202	Тэтгэмжийн даатгал	10,440,700.0	10,440,700.0	0.0	100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,352,500.0	8,352,500.0	0.0	100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	2,088,100.0	2,088,100.4	-0.4	100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	20,881,300.0	19,835,611.5	1,045,688.5	94.99
2105	Нормативт зардал	185,362,600.0	171,834,650.0	13,527,950.0	92.70
210502	Хоол, хүнс	185,362,600.0	171,834,650.0	13,527,950.0	92.70
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	14,199,500.0	14,158,900.0	40,600.0	99.71
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,893,900.0	3,893,900.0	0.0	100.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	10,305,600.0	10,265,000.0	40,600.0	99.61
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	108,220,100.0	106,705,480.0	1,514,620.0	98.60
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	92,761,700.0	91,266,930.0	1,494,770.0	98.39
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	15,458,400.0	15,438,550.0	19,850.0	99.87
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	71,776,800.0	71,191,500.0	585,300.0	99.18
2132	Бусад урсгал шилжүүлэг	71,776,800.0	71,191,500.0	585,300.0	99.18
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	71,776,800.0	71,191,500.0	585,300.0	99.18
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,554,130,700.0	1,554,130,700.0	0.0	100.00
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,547,686,800.0	1,547,686,800.0	0.0	100.00
310001	Улсын төсвөөс санхүүжих	1,547,686,800.0	1,547,686,800.0	0.0	100.00

35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	6,443,900.0	6,443,900.0	0.0	100.00
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,893,900.0	3,893,900.0	0.0	100.00
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,550,000.0	2,550,000.0	0.0	100.00
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.0	30,262,352.8	-30,262,352.8	0.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан /Орон төсөв/

/төгрөг/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	гүйцэтгэл	Зөрүү	бнелэлт
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	332,066,500.0	331,453,402.0	613,098.00	99.8
21	УРСГАЛ ЗАРДАЛ	332,066,500.0	331,453,402.0	613,098.00	99.8
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	332,066,500.0	331,453,402.0	613,098.00	99.8
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	67,730,121.0	67,730,121.0	0.00	100.0
210101	Үндсэн цалин	67,730,200.0	57,132,775.0	10,597,425.00	84.4
210102	Нэмэгдэл	0.0	5,273,099.0	-5,273,099.00	0.0
210104	Урамшуулал	0.0	5,324,247.0	-5,324,247.00	0.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	8,453,200.0	8,453,129.0	71.00	100.0
210201	Тэтгэврийн даатгал	6,084,600.0	5,864,173.0	220,427.05	96.4
210202	Тэтгэмжийн даатгал	632,200.0	689,901.2	-57,701.21	109.1
210203	ҮОМШӨ-ний даатгал	502,400.0	548,560.9	-46,160.85	109.2
210204	Ажилгүйдлийн даатгал	112,200.0	122,772.3	-10,572.27	109.4
210205	Эрүүл мэндийн даатгал	1,121,800.0	1,227,721.7	-105,921.72	109.4
2106	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	250,383,100.0	249,770,152.0	612,948.00	99.8
210601	Гэрэл цахилгаан	8,150,000.0	6,413,850.0	1,736,150.00	78.7
210602	Түлш, халаалт	239,870,800.0	240,901,102.0	-1,030,302.00	100.4
210603	Цэвэр бохир ус	2,362,300.0	2,455,200.0	-92,900.00	103.9
	Эд хогшил худалдан авах	5,500,000.0	5,500,000.0	0.00	100.0
	Урсгал засвар	5,500,000.0	5,500,000.0	0.00	100.0
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	332,066,500.0	332,066,500.0	0.00	100.0
31	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	332,066,500.0	332,066,500.0	0.00	100.0
310001	Орон нутгийн төсвөөс санхүүжих	332,066,500.0	332,066,500.0		100.0

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Багшийн мэргэжлийн хөгжлийг дэмжих хүүхэд бүрийн сурч хөгжих сургалтын таатай орчин бүрдүүлэн сургалтын чанар үр дүнд ахиц гаргах зорилго тавин ажиллаж байна. Ардын өв уламжлал, ёс заншил, зорилтод хөтөлбөрүүдийг хэрэгжүүлсэн тоглоом наадгайгаар дамжуулан бүтээлч үйлийн орчин бүрдүүлэн ард иргэдийн итгэл хүлээсэн инээж угтаж, сургуулийн өмнөх боловсролын сурагчдад эзэмшүүлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байгууллага юм.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- ✓ Хөдөлмөрийн тухай хууль - Шинэчлэн найруулгыг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдөж эхэлсэн.
- ✓ Төрийн хэмнэлтийн тухай хууль - 2022 оны 04 дүгээр сарын 29-ний өдөр батлагдсан.
- ✓ Төрийн албаны тухай хуульд 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр, 7 дугаар сарын 05-ны өдөр, 11 дүгээр сарын 11-ний өдөр нэмэлт өөрчлөлтүүд оруулсан байна.
- ✓ Төсвийн тухай хуульд 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр, 7 дугаар сарын 01-ний өдөр, 8 дугаар сарын 29-ний өдөр, 11 дүгээр сарын 11-ний өдөр
- ✓ Засгийн газрын 2018 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 382 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журам"
- ✓ Засгийн газрын 2019 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн 276 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт
- ✓ Засгийн газрын 2022 оны 03 дугаар сарын 09-ний өдрийн 107 дугаар тогтоолын 7 дугаар хавсралт
- ✓ Сангийн сайдын 2022 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн 120 дугаар тушаал "Албан томилолтын зардлын тариф" тус тус нэмэлт өөрчлөлт оруулсан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Тариалан сумын Ерөнхий боловсролын нэгдүгээр сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Тариалан сумын Ерөнхий боловсролын нэгдүгээр сургуулийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос мянган төгрөгөөр буюу 1.3 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0	30,262.30	30,262.30
Авлага	0	0	0.00
Бараа материал	133,749.00	142,020.40	8,271.40
Үндсэн хөрөнгө	5,293,041.50	5,180,722.70	-112,318.80
Нийт хөрөнгө	5,520,310.50	5,446,525.70	-73,784.80
Өр төлбөр	0	0	0.00
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	5,520,310.50	5,446,525.70	-73,784.80
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	5,520,310.50	5,446,525.70	-73,784.80

Тайлант оны эхэнд тэг төгрөг эцэст мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 30,262.3 мянган төгрөг болж өссөн нь улсын төсвийн дансны үлдэгдэл төвлөрүүлээгүйтэй холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 142,020.4 мянган төгрөг болж 8,271.4 мянган төгрөгөөр аж ахуйн материалын үлдэгдэл өссөн байна. Бараа материалын дансны үлдэгдэлд худалдаж авсан ашиглалтгүй бараа материал байхгүй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 5,180,722.7 мянган төгрөг болж буурсан нь үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал өссөнтэй холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 5,446,525.7 мянган төгрөг болж 73,784.8 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүн нэмэгдсэнээс шалтгаалжээ.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тариалан сумын Ерөнхий боловсролын нэгдүгээр сургуулийн 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 1,849,508.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслийг 1,849,508.0 мянган төгрөгөөр баталсныг төсвийн тодотгол хийгдэж 36,689.2 мянган төгрөгөөр өсгөсөн байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд 1 хөтөлбөрийн 9 арга хэмжээг санхүүжүүлэхээр улсын төсвөөс 1,547,686.8 мянга, орон нутгийн төсвөөс 332,066.5 мянга, үйл ажиллагааны орлогоос 6,443.9 мянга, нийт 1,886,197.2 мянган төгрөгийн төсөв баталсан байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,547,686.8 мянга, орон нутгийн төсвөөс 332,066.5 мянган төгрөгийн санхүүжилт, үйл ажиллагааны орлогоос 6,443.9 мянган төгрөгийн санхүүжилт авсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,855,321.7 мянган төгрөг буюу 98.9 хувьтай байгаа нь орон нутгийн төсвийн үндсэн үйл ажиллагааны зардлын 613.0 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн, улсын төсвийн дансанд 30,262.3 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/					
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Улсын төсвийн үндсэн үйл ажиллагааны зардал	1,554,130.7	1,523,868.3	30,262.3	98.1%
2	Орон нутгийн үндсэн үйл ажиллагааны зардал	332,066.5	331,453.4	613.0	99.8%

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,855,321.7 мянган төгрөг буюу 98.9 хувьтай байгаа нь цалин урамшууллын зардлыг 13,548.2 мянга, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардлыг 1,045.7 мянга, хүүхдийн хоолны зардлыг 13,527.9 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлыг 40.6 мянга, бараа үйлчилгээний бусад зардлыг 1,514.6 мянга, төрөөс иргэд олгох тэтгэмж, урамшууллын зардлыг 585.3 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "Нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн дансаар орлого зарлага гараагүй байна.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Түргэн сумын Ерөнхий боловсролын сургууль нь тайлант онд хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөр байхгүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Тариалан сумын Ерөнхий боловсролын нэгдүгээр сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг “Увс Финанс Аудит” ХХК-ийн аудитор Я.Тунгалаг гүйцэтгэж, анхан шатны хяналтыг захирал Я.Нарантуяа, чанарын хяналтыг Увс аймгийн Төрийн аудитын газрын аудитын менежер М.Бат-Амгалан, дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь нар тус тус хэрэгжүүлсэн.

Тариалан сумын Ерөнхий боловсролын нэгдүгээр сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Увс финанс аудит ХХК-д 2023 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн 04 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1,670.3 сая төгрөгөөс 0.5 хувиар буюу 8.3 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн. Гүйцэтгэлийн шатанд материаллаг байдлыг 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 1,968.7 сая төгрөгийн 0.5 хувь буюу 9.8 сая төгрөгөөс 80 хувиар буюу 7.8 сая төгрөгөөр тогтоосон.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Тариалан сумын Ерөнхий нэгдүгээр боловсролын хувьд Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор хамаарах зүйл заалтын хүрээнд зөрчил гараагүй байна. /АБ-4/

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор

www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд www.shilendans.gov.mn цахим хуудсанд оруулбал зохих 151 мэдээллээс байршуулах хугацаа болоогүй 2, хугацаа хоцроож 3, хугацаандаа оруулсан 146 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Түргэн сумын Ерөнхий боловсролын сургууль нь Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.5 дахь хэсэгт “Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй” гэж заасныг хэрэгжүүлэн ажиллаагүй байна.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Тариалан сумын Ерөнхий боловсролын нэгдүгээр сургуулийн 2022 оны санхүүгийн тайланд завсрын аудит хийгээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар тогтоосон төлбөрийн актыг бүрэн барагдуулж ажилласан байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	485.5	1	485.5	100%
Албан шаардлага					
Зөвлөмж					
Нийт дүн	1	485.5	1	485.5	100%

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Тариалан сумын Ерөнхий боловсролын нэгдүгээр сургуулийн хувьд дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй болно.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар зөрчил илрээгүй болно.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Дүн												

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Дүн												

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Нийт дүн								

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  /М.БАТЦУУРЫ/

АУДИТЫН МЕНЕЖЕР  /М.БАТ-АМГАЛАН/

БЭЛТГЭСЭН:

УВС ФИНАНС АУДИТ ХХК-ийн АУДИТОР  /Я.ТУНГАЛАГ/

2023 оны 02 дугаар сарын 24-ний өдөр